



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 08 сарын 12 өдөр

Дугаар 754

Улаанбаатар хот

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах
үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.6, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.6, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Инвекор актив” ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус компанийн гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төлбөрийг гүйцэтгэх эцсийн хугацаанаас багагүй хугацаагаар олгосугай.

2. Энэ тогтоолын 1-д заасан тусгай зөвшөөрлийг олгосонтой холбогдуулан компанийн эрхлэх үйл ажиллагааны төрөл болон оноосон нэрд өөрчлөлт оруулж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн энэ тухай Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор мэдэгдэхийг “Инвекор актив” ХХК /Б.Хишигтөр/-д үүрэг болгосугай.

3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож байгаатай холбогдуулан “Инвекор актив” ХХК /Б.Хишигтөр/ болон “Инвекор ББСБ” ХК /Д.Баясгалан/, “Микрокредит ББСБ” ХХК /Г.Булганчимэг/-д дараах арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосугай:

1/ Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх;

2/ Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журамд заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлэх.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Г.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН